



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 19 өдөр

Дугаар A/346

Есенбулаг сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 135 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:


1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжигдэх ГААХААГ/20250201033 дугаар бүхий "Газрын доройтол цөлжилтээс сэргийлж гадаргын ус, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажил"-ыг "Ханан сэрх харуул хайрхан" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Байгаль орчны газар (Д.Батмагнай)-т олгосугай.

2. Ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлagnаж ажиллахыг Байгаль орчны газар (Д.Батмагнай)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Санхүү төрийн сангийн хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ



ମୁଦ୍ରଣ ତାରିଖ

፳፻፷፭ በኋላውን አዲት ተስተካክል ዓመታዊ



ପ୍ରତିକାଳି - ହୋଲି ମାନ୍ୟମାନୀ ଏବଂ ଜୀବନୀ ଅନୁଷ୍ଠାନିକ ଏବଂ ଜୀବନୀ
ଚାରିକାଳୀନୀ